МОНГОЛЬСКАЯ АКАДЕМИЯ НАУК
Институт истории и археологии

МЕЖДУНАРОДНАЯ АССОЦИАЦИЯ МОНГОЛОВЕДОВ

РОССИЙСКАЯ АКАДЕМИЯ НАУК
Институт восточных рукописей

# КУЛЬТУРНОЕ НАСЛЕДИЕ МОНГОЛОВ: КОЛЛЕКЦИИ РУКОПИСЕЙ И АРХИВНЫХ ДОКУМЕНТОВ

## III

**Международная конференция**
**при поддержке Президента Монголии**



20-22 апреля 2017 г. Санкт-Петербург

Сборник докладов

Санкт-Петербург - Улан-Батор
2019

ННА-72
ДАА-378.121
М-694

**Ответственный редактор:** Академик С.Чулуун
**Редакторы, составители:** доктор филол.наук И.В.Кульганек
Ph.D Н.Хишигт
Ph.D Б.Нацагдорж
Ph.D Н.В.Ямпольская
**Рецензенты:** Ph.D Н.Ганбат
доктор филол.наук Л.Г.Скородумова

**Культурное наследие монголов: коллекции рукописей и архивных документов.** Сборник докладов III международной научной конференции. 20-22 апреля 2017 г. Санкт-Петербург. Россия. СПб.-УБ., 2019 г. -254 с.

Сборник представляет собой собрание докладов III международной научной конференции “**Культурное наследие монголов: коллекции рукописей и архивных документов”**, организованной Институтом истории и археологии МАН и Институтом восточных рукописей РАН в г.Санкт-Петербург, 20-22 апреля 2017 г.

Основой для конференции стали рукописные фонды и архивы, хранящие документы и материалы по истории, культуре, этнографии, политике, языку монгольских народов.

В сборнике публикуются доклады, освещающие историю монголоведения, а также доклады, посвященные рукописным материалам о материальной культуре монголов, их письменному наследию, художественному творчеству, экспедициям и разным сторонам жизни традиционного и современного монгольского общества.

ISBN 978-99978-773-4-5
DOI 10.25882/76vd-bb41

© Институт истории и археологии МАН, 2019 г.
© Институт восточных рукописей РАН, 2019 г.
© Международная Ассоциация монголоведов, 2019 г.

**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ**
**Түүх, археологийн хүрээлэн**

**ОЛОН УЛСЫН МОНГОЛ СУДЛАЛЫН ХОЛБОО**

**ОХУ-ЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ**
**Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн**

Монгол улсын ерөнхийлөгчийн ивээл дор
зохион байгуулсан

# МОНГОЛЧУУДЫН СОЁЛЫН ӨВ: ГАР БИЧМЭЛ БА АРХИВЫН БАРИМТЫН ЦУГЛУУЛГА

# III

**Олон улсын эрдэм шинжилгээний хурал**



2017 оны 4 сарын 20-22
ОХУ-ын Санкт-Петербург хот

Илтгэлүүдийн эмхэтгэл

Санкт-Петербург - Улаанбаатар
2019 он

ННА-72
ДАА-378.121
М-694

**Хариуцлагатай редактор:** Академич С.Чулуун
**Редактор, эмхэтгэгчид:** Хэл бичгийн ухааны доктор И.В.Кульганек
Ph.D Н.Хишигт
Ph.D Б.Нацагдорж
Ph.D Н.В.Ямпольская
**Шүүмжлэгчид:** Ph.D Н.Ганбат
Хэл бичгийн ухааны доктор Л.Г.Скородумова

**Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга.** Олон улсын эрдэм шинжилгээний III хурлын илтгэлүүдийн эмхэтгэл. ОХУ. Санкт-Петербург хот. 2017 оны 4 дүгээр сарын 20-22. СПб-УБ., 2019. 254 тал.

Монгол улсын ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн ба Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэнгээс 2017 оны 4 дүгээр сарын 20-22-нд ОХУ-ын Санкт-Петербург хотноо **"Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга"** 3 дахь удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулав.

ОХУ, Монгол улсын гар бичмэлийн сан хөмрөг, архивуудад хадгалагдаж байгаа монгол угсаатан ард түмнүүдийн түүх, хэл, соёлын арвин баялаг эх сурвалж нь тус хурлын эх суурь болсон юм.

Эмхэтгэлд монгол судлалын түүх, монголчуудын эдийн соёл, бичгийн өв, уран сайхны бүтээл туурвил, Монголын уламжлалт ба орчин үеийн нийгмийн олон талт амьдралыг тусгасан гар бичмэл, баримт, эх хэрэглэгдэхүүнийг судлан шинжилсэн илтгэлүүд багтсан болно.

ISBN 978-99978-773-4-5
DOI 10.25882/76vd-bb41

© Монгол улсын ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, 2019
© ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, 2019.
© Олон улсын Монгол Судлалын Холбоо, 2019.

MONGOLIAN ACADEMY OF SCIENCES
Institute of History and Archeology

INTERNATIONAL ASSOCIATION FOR MONGOL STUDIES

RUSSIAN ACADEMY OF SCIENCES
Institute of Oriental Manuscripts

# III

# CULTURAL HERITAGE OF THE MONGOLS: MANUSCRIPT AND ARCHIVAL COLLECTIONS

**The International Conference under the Patronage of the President of Mongolia**



April 20-22, 2017. St.Petersburg, Russia

Proceedings

St.Petersburg - Ulaanbaatar
2019

ННА-72
ДАА-378.121
М-694

**Editor-in-Chief:** Academician S.Chuluun
**Edited and compiled by:** Doctor of Philology I.V.Kulganek
Ph.D N.Khishigt
Ph.D B.Natsagdorj
Ph.D N.V.Yampolskaya
**Reviewers:** Ph.D N.Ganbat
Doctor of History L.G.Skorodumova

**Cultural heritage of the Mongolis: manuscripts and archival collections.** Papers of the III International Conference, April 20-22, 2015. St. Petersburg, Russia. St.Petersburg. -Ulaanbaatar 2017, 254 pp.,

This is a collection of papers, presented at the Third International Conference organized by the Institute of History and Archeology of the Mongolian Academy of Sciences and the Institute of Oriental Manuscripts of the Russian Academy of Sciences, which was held in St. Petersburg on April 20-22, 2017.

The basis for the conference was hand-written funds and archives, storing documents and materials on history, culture, ethnography, politics, language of the Mongolian peoples.

The collection publishes reports on the history of Mongolian studies, as well as reports on handwritten material on the Mongolian culture, their written heritage, artistic creativity, expeditions and the problems of traditional and Modern Mongolian society.

ISBN 978-99978-773-4-5
DOI 10.25882/76vd-bb41

© Institute of History and Archeology, MAS 2019
© Institute of Oriental Manuscripts, RAS 2019
© International Association For Mongol Studies, 2019.

# ГАРЧИГ / СОДЕРЖАНИЕ / CONTENT

МЭНДЧИЛГЭЭ / ПРИВЕТСТВИЯ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн мэндчилгээ ........ 9

Приветствие директора Института восточных рукописей РАН, доктора исторических наук, профессора И.Ф.Поповой ........ 11

Монгол Улсын ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн захирал, Олон улсын Монгол Судлалын Холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга, Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор С.Чулууны мэндчилгээ ........ 15

Монгол Улсын Соёл, Урлагийн Их сургуулийн захирал, доктор, профессор Э.Сонинтогосын хэлсэн үг ........ 17

ИЛТГЭЛҮҮД / ДОКЛАДЫ

*Ц.П.Ванчикова*

Положения о религиозной администрации («Šasin-u jakirγan-u dürim») как источники по истории буддизма в Монголии ........ 20

*Дуутан Ж.Гэрэлбадрах*

Кем были «иргэн/irgen»? ........ 28

*Ж.Долгорсүрэн*

Целостность культурного наследия «Монгол цуур» ........ 38

*Ю.И.Дробышев*

Кочевая имперская традиция и ее эволюция ........ 44

*Б.С.Дугаров*

Культ Гэсэра в Саяно-Прихубсугулье ........ 57

*Ю.И.Елихина*

Некоторые находки из монастыря Сарьдаг, хранящиеся в Государственном Эрмитаже ........ 65

*И.М.Захарова*

Образы монголов в гравюрах второй половины XVIII - начала XIX вв. из собрания Государственного Эрмитажа ........ 73

*И. В. Кульганек*

Ц.Ж.Жамцарано «О собирании фольклора»: по материалам Архива востоковедов ИВР РАН ........ 82

*М.П.Петрова*

Архивные материалы о монгольских студентах в Ленинграде в 20-е гг. XX в. из ЦГА ........ 91

*Р.Ю.Почекаев*
Политико-правовые взгляды Хутуктай-Сэчена-Хунтайджи (По данным «Белой истории») ..... 107
*П.О.Рыкин*
Чтение монгольской надписи на Тырской стеле 1413 г.: новые подходы и результаты ..... 121
*С.С.Сабрукова*
Эпистолярное наследие калмыков XVIII века ..... 141
*Ж.Саруулбуян*
Марзан Шаравын шинээр олдсон нэгэн бүтээлийн тухай ..... 151
*Ц.Б.Селеева*
Фольклор монгольских народов в записях А.В.Бурдукова: из архивной коллекции КНЦ РАН ..... 161
*Д.Д.Селюнина*
Особенности употребления термина Ejen в монгольском сочинении XVII в. «Erdeni tunumal neretü sudur» ..... 172
*Л.Г.Скородумова*
Рукописное наследие В.Инжинаша: «Повесть о Лунной кукушке» ..... 183
*Т.Д.Скрынникова*
«*Эрдэнийн эрихэ*» о властных отношениях в Халхе 1636-1736 гг. ..... 188
*С.Соронзонболд, Ц.Цэвэгсүрэн*
Особенности и виды обозначений мелодий в музыкальных сутрах ..... 197
*С.Чулуун*
Краковын архив дахь «Тод» үсгийн хэдэн захидлын тухай ..... 204
*Т.И.Юсупова*
Первый официальный визит монгольских ученых в Академию наук СССР и создание Академии наук МНР ..... 209
*Л.Эрдэнэболд, Б.Пүрэвсүрэн*
Археологические исследования историко-культурных памятников Монголии, связанных с историей Халхи XVII века ..... 219
*Н.С.Яхонтова*
Тибетско-Монгольская рукопись тематического словаря из собрания ИВР РАН ..... 230

АВТОРЫ ..... 246
ЗОХИОГЧИД ..... 250

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ

ЭРХЭМ ХҮНДЭТ ЭРДЭМТЭН СУДЛААЧИД АА!

Юуны өмнө Та бүхэнд тус хуралд хүрэлцэн ирсэнд баяр хүргэж, эрдэм судлалын өндөр амжилт хүсэн ерөөе.

Миний бие одоогоос 6 жилийн өмнө тус хотод айлчлах үед Санкт-Петербургийн монгол судлаач Та бүхэнтэй уулзаж, Монголын гайхамшигт өв соёлтой танилцаж байсан. Тэр үед Та бүхэн энэ хурлын тухай санал хэлж бидний зүгээс дэмжихээ амалсан. Анхны хурлыг Монгол улсын ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнтэй хамтран Санкт-Петербургт зохион байгуулснаас хойш одоо 3 дахь удаагаа зохион байгуулагдаж байгаад нэн баяртай байна. Монгол, Оросын эрдэмтдийн сайн хамтын ажиллагаа, ойлголцолын үр дүн гэж шууд ойлгож байна.

Тус хурал нь Орос, Монголын архивын баримтын цуглуулга, гар бичмэл, археологийн өв соёлын олон асуудлаар эрдэмтэд санал, бодлоо солилцдог томоохон талбар болж чадаж байгаа гэдэгт огтхон ч эргэлзэхгүй. Мөн тус хурал зөвхөн Орос, Монголын эрдэмтэн судлаачдаар хязгаарлагдахгүй өрнө, дорнын олон орны эрдэмтэд оролцож, жил ирэх тусам өргөжиж байгаа нь үүний нэгэн нотолгоо юм.

Монгол улсын талаас тодорхой дэмжлэгийг үзүүлж байгаа ч гэсэн Оросын эрдэмтэд Та бүхэн өөрт хадгалагдаж байгаа баялаг эх хэрэглэгдэхүүн, мэдээ мэдээллээр хангаж өгч байгаа нь ихээхэн чухал үүрэгтэй. Цаашид хоёр орны эрдэмтэн судлаачид улам өргөн хүрээнд хамтран ажиллаж, Санкт-Петербург болон Улаанбаатарын архив, номын сан, судалгааны хүрээлэнгүүдийн архив, гар бичмэлийн цуглуулгаас томоохон цуврал бүтээлүүдийг хамтран хэвлэн нийтлүүлэх, судлан шинжлэх, монгол судлалын талбарт гаргахад бодитой ажлуудыг хийж эхлэнэ гэж найдаж байна.

Монгол улсын Ерөнхийлөгч миний бие цаашид ч уг хурал, хамтын ажиллагааг бүрэн дэмжиж байхаа мэдэгдэхийн зэрэгцээ 2019 онд Монгол улсад болох IV дэх удаагийн хуралд өөрийн биеэр оролцоно гэж амлаж байна.

Монгол судлалын ертөнцөд гайхамшигт бүтээлүүд гарах болтугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ



ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ

Төрийн ордон, Улаанбаатар хот
2017 оны 4 дүгээр сарын 20

# ПРИВЕТСТВИЕ ДИРЕКТОРА ИНСТИТУТА ВОСТОЧНЫХ РУКОПИСЕЙ РАН, ДОКТОРА ИСТОРИЧЕСКИХ НАУК, ПРОФЕССОРА И.Ф.ПОПОВОЙ

ДОРОГИЕ УЧАСТНИКИ!
КОЛЛЕГИ, ДРУЗЬЯ!

Разрешите от имени Института восточных рукописей РАН приветствовать Вас на открытии сегодняшнего значимого мероприятия!

Мне приятно отметить, что научное сотрудничество, закрепленное Договором между ИВР РАН и Институтом истории и археологии МАН в 2013 году, развивается чрезвычайно плодотворно и демонстрирует блестящие успехи.

Это третья международная конференция, которая проводится совместно нашими Институтами. Первая конференция была проведена в Санкт-Петербурге 19-20 апреля 2013 года и называлась «Культурное наследие монголов: рукописные и архивные собрания Санкт-Петербурга и Улан-Батора». Конференция проходила при поддержке Президента Монголии Ц.Элбэгдоржа. Вместе с Правительством Монголии соорганизатором выступила также Международная ассоциация монголоведов. Проведение первого совместного мероприятия стало одним из итогов официального визита Президента Монголии в Российскую Федерацию в мае 2011 года, когда во время своего пребывания в Санкт-Петербурге Ц.Элбэгдорж знакомился с памятниками истории и культуры Монголии, хранящимися в городе и 31 мая 2011 года посетил ИВР РАН. В ходе беседы с монголоведами Президент, подчеркнув необходимость дальнейшего расширения сотрудничества ученых обеих стран, выразил готовность оказать содействие созданию совместных трудов и организации научных мероприятий.

Первая совместная конференция была посвящена коллекциям Санкт-Петербурга и Улан-Батора, где хранятся уникальные рукописные и архивные памятники богатейшего духовного и культурного наследия монгольского народа, сформировавшегося на обширной территории Центральной Азии в результате взаимодействия носителей разных хозяйственных укладов, культурных традиций, духовных ценностей. Письменное и устное духовное наследие стало подтверждением этнокультурной и национальной идентичности, предметом гордости, солидарности и патриотизма монголов. На конференции была принята резолюция, по которой было выражено намерение проводить подобные мероприятия один раз в два года: поочередно в Санкт-Петербурге и Улан-Баторе.

Прошедшие пять лет показали жизненность инициативы монгольских и российских ученых. На последующих конференциях была расширена тематика докладов, в них приняли участие помимо ученых Санкт-Петербурга и Улан-Батора, исследователи из других регионов России - Москвы, Улан-Удэ, Иркутска, Казани, а также ряд иностранных специалистов - из Японии, Венгрии, Польши, Китая.

Большая заслуга в организации постоянной конференции «Культурное наследие монголов», принадлежит тем, кто стоял у ее истоков - Президент Монгольской академии наук Б.Энхтувшин, и основной организатор и активный исполнитель этой идеи - директор Института истории и археологии МАН, советник по науке действующего Президента Монголии Х.Баттулга, генеральный секретарь Международной ассоциации монголоведов С.Чулуун.

Приятно отметить, что все вдохновители и организаторы конференции считают расширение исследований по истории письменного наследия Монголии чрезвычайно важным направлением в монгольском, российском и мировом востоковедении, и что архивные источники и рукописные материалы, хранящиеся в России, Монголии, других странах мира, представляют собой особую научную ценность. Участники проводимых ИВР РАН и ИИА МАН конференций вводят в научный оборот уникальные памятники письменности монголов и документы из собраний Института восточных рукописей РАН, Санкт-Петербургского

государственного университета, Санкт-Петербургского филиала Архива РАН, Государственного Эрмитажа, Центрального национального архива Монголии, Национальной библиотеки Монголии, Института истории и археологии МАН и Института языка и литературы МАН, Венгерской академии наук, Музея этнологии в Токио, Варшавского университета и многих других научных центров мира.

Нынешняя конференция, как и все предыдущие, имеет богатейшую научную базу и благородную цель, состоящую в расширении исследований, выявлении новых источников и материалов, выдвижении передовых идей, разработке новых тенденций в исследовании истории, этнографии, культуры, языка и фольклора монгольского народа. В конференции участвуют высокопрофессиональные специалисты, чьи доклады и выступления представят новейшие научные идеи и достижения в исследовании рукописных и архивных материалов.

За время работы постоянной конференции научному сообществу были представлены новые документы о научной деятельности монголоведов В.Л.Котвиче, В.П.Васильеве, С.А.Козине, О.М.Ковалевском, Н.Н.Поппе, В.А.Казакевиче, Г.И.Боровке. Традиция введения в научный оборот новых архивных данных будет поддержана и настоящей конференцией.

Участники обсудят важнейшие актуальные проблемы, касающиеся разных сторон жизни и культурного наследия монголов. В тематике обсуждений представлены: терминология социально-политической структуры в монгольских летописях XIII-XVII вв., роль исторических личностей в истории ойратов, современное состояние и перспективы изучения традиционного монгольского права, традиционные обряды монгольских народов, устное народное творчество монголов, история монголоведения на Востоке и Западе, международное монголоведное сотрудничество в разные исторические эпохи, исследование сочинений популярного буддизма, философии, памятников письменности.

Конференция «Культурное наследие монгольских народов» вызывает большой интерес российского, монгольского и мирового монголоведного сообщества. Она является свидетельством

большого вклада Правительства Монголии в развитие мирового монголоведения и результатом сотрудничества монгольских ученых с учеными Санкт-Петербурга, Института восточных рукописей РАН, старейшего центра мирового монголоведения, отмечающего в 2018 году свой 200-летний Юбилей.

Желаю всем участникам постоянной международной конференции «Культурное наследие монгольских народов: рукописные и архивные собрания» плодотворной работы, творческих успехов и высоких результатов.

# МОНГОЛ УЛСЫН ШУА-ИЙН ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ, ОЛОН УЛСЫН МОНГОЛ СУДЛАЛЫН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР, ПРОФЕССОР С.ЧУЛУУНЫ МЭНДЧИЛГЭЭ

ЭРХЭМ ХҮНДЭТ ЭРДЭМТЭН МЭРГЭД, ЗОЧИД ОО!

Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагддаг «Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга» олон улсын эрдэм шинжилгээний хурлыг анх 2013 оны 4 дүгээр сард ОХУ-ын Санкт-Петербург хотноо эхлүүлж байсан юм.

Тус хурлыг зохион байгуулах саналыг 2011 оны 5 сард Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж ОХУ-ын Санкт-Петербург хотод айлчлах үед Оросын талаас монгол судлаачид дэвшүүлж, Монгол Улсын талаас ШУА-ийн Түүхийн хүрээлэн хамтран зохион байгуулахаар болсон юм. Хурлыг «Монголчуудын соёлын өв: Улаанбаатар, Санкт-Петербург хот дахь гар бичмэл ба архивын баримтын цуглуулга» нэрийн дор хийсэн. Энэ нь монголын судлалын хүрээнд нэлээд сонирхол татаж, хоёрдугаар удаагаас эхлэн агуулга, цар хүрээ нь өргөжин тэлсэн бөгөөд зөвхөн Улаанбаатар, Санкт-Петербургийн хэмжээнд авч үзэх боломжгүй болсон юм.

Өөрөөр хэлбэл дэлхийн бусад улс орны эрдэмтэд өөрийн улс орнуудад буй Монголын түүх, соёлын өв, сурвалж болон архивын баримтын талаар илтгэл хэлэлцүүлэх болсон. Тус хурлыг нийтдээ 3 удаа зохион байгуулаад байгаа бөгөөд хоёр жилд нэг удаа Санкт-Петербург, Улаанбаатар хотод ээлжлэн зохион байгуулж, Монгол улсын ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгээс санхүүжүүлдэг болно.

Монголын бүхий л үеийн түүх, соёл, эх сурвалж, архивын баримтын талаар чиглэсэн судалгааг явуулж ирсэн нэр хүндтэй эрдэмтэн судлаачид, байгууллагууд оролцож байгаа нь тухайн олон

улсын хурлын нэр хүндийг өндөрт өргөж байна. 2013 онд Санкт-Петербург хотод, 2015 онд Монгол улсад, 2017 онд Санкт-Петербург хотод тус тус зохион байгуулагдсан энэхүү хурлыг өнөөдөр дэлхийн монгол судлаачид ихээхэн сонирхохын зэрэгцээ идэвхтэй оролцдог болоод байгаа нь сайшаалтай.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагддаг тус хурал нь Монголын соёлын өв, Орос, Монголын эрдэм судлалын харилцаа, эрдэмтдийн хамтын ажиллагааг өргөтгөх, идэвхжүүлэхэд чухал ач холбогдолтой томоохон арга хэмжээ болсон бөгөөд ОХУ-ын талаас ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, Дорно дахины судлалын хүрээлэн, Сибирийн салбарын Буриадын Монгол, Төвд, Буддын судлалын хүрээлэн, Халимагийн хүмүүнлэгийн судалгааны хүрээлэн, Тувагийн Хүмүүнлэгийн ба хавсрага судалгааны хүрээлэн, Оросын ШУА-ийн архивын Санкт-Петербургийн салбар, Их Петр хааны нэрэмжит Антропологи, этнографийн музей (Кунсткамера), Улсын Эрмитаж, Оросын Угсаатны зүйн музей, Орос улсын Хүмүүнлэгийн их сургууль зэрэг олон байгууллага идэвхтэй дэмжиж оролцсонд талархал илэрхийлж байна.

Тус хуралд хэлэлцүүлсэн сонирхолтой баримт материалууд, соёлын өвийн дурсгалуудыг хамтран судлах, хэвлэн нийтлүүлэх, хуулбарлаж авах ажлыг ихээхэн идэвхжүүлж байгаа нь сүүлийн жилүүдэд эрс мэдэгдэж байна.

Энэхүү хурлыг цаашид чадахын хирээр үргэлжлүүлэн явуулахад ерөнхий зохион байгуулагч байгууллагууд идэвхтэй хүчин чармайлт гаргаж байгаа билээ.

# МОНГОЛ УЛСЫН СОЁЛ УРЛАГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ, ДОКТОР, ПРОФЕССОР Э.СОНИНТОГОСЫН ХЭЛСЭН ҮГ

ЭРХЭМ ХҮНДЭТ ЗОЧИД ОО!
ЭРДЭМТЭН СУДЛААЧИД АА!

Миний бие өнөөдөр Санкт-Петербург хотод Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн дээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдаж байгаа «Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга» 3 дахь удаагийн олон улсын хуралд оролцож байгаадаа баяртай байна.

Монгол судлалын баялаг уламжлалыг үргэлжлүүлж, Европ дахь монгол судлалын томоохон голомтыг бадрааж байдагт нь ОХУ-ын эрдэмтэн, судлаачдад талархал илэрхийлье.

Нийгэм-хүмүүнлэгийн шинжлэх ухааны олон салбар нь соёл судлалаас ангид байх аргагүй юм. Олон улсын монгол судлалд Монголын соёл, урлаг судлал өөрийн гэсэн томоохон орон зайг эзэлдэг билээ.

Монголын соёл урлаг судлалыг хөгжүүлэхэд Соёл, урлагийн их сургууль идэвхитэй оролцож, эрдэм шинжилгээний ажлыг эрчимжүүлэх, сургалт-судалгааны ажлын уялдаа холбоог бэхжүүлэх, хүмүүнлэгийн салбарт инновацийг хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Манай эрдэмтэд судалгааны тэргүүлэх чиглэлийн хүрээнд хөгжим, бүжиг, дүрслэх урлаг, театр, медиа болон соёл судлалын чиглэлээр олон төсөл хөтөлбөр хэрэгжүүлж буйн дотор монгол эртний эгшиг тэмдэглээ ян-ег-ийн судалгаа, уртын дуу, хөөмий, монгол туулийн судалгааг тогтвортой хийж, Швед улсын Угсаатны музейд өнгөрсөн зуунаас хадгалагдан ирсэн 200 гаруй монгол дууг судлан үг, нootыг сэргээж; Хубилай хааны ордны долоо, ес, арван нэгэн чавхдаст ятга, хурган чих хөгжмийг сэргээн судалгаа, сургалт, уран бүтээлийн эргэлтэд оруулах; Монголын дүрслэх урлагийн язгуур хэв шинжийг тодорхойлох; хосгүй үнэт бүтээлийг хуулбарлах, сэргээн засварлах салбарт амжилттай ажиллаж, эрдэм шинжилгээний ном зохиол, этно-модерн бүжгэн жүжиг, хөгжим, дүрслэх урлагийн инновацийн бүтээлүүдийг туурвиж байна.

Тус сургууль дэлхийн соёл, урлагийн хөгжилд ч өөрийн хувь нэмрийг оруулахыг хичээж байгаа бөгөөд манай төгсөгчид, Монголын дуурийн дуулаачид ОХУ-ын Их театр, Марийнскийн театр, Миланы Ла скала, Берлиний дуурийн театр зэрэг дэлхийн сонгодог урлагийн томоохон тайзнаа дуулж, багш нарын бүтээлүүд Венец, Берлин, Бээжингийн үзэсгэлэнгүүдэд дэлгэгдэж байна. Бид ЮНЕСКО болон Азийн театрын боловсролын төвтэй хамтран олон улсын фестиваль, чуулга уулзалтуудыг амжилттай зохион байгуулж, эрдэм шинжилгээний төсөл хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол улсын Соёл, урлагийн их сургууль нь ОХУ-ын их дээд сургуулиудтай олон жил хамтран ажиллаж ирсэн баялаг уламжлалтай бөгөөд сүүлийн жилүүдэд Санкт-Петербургийн Улсын их сургууль, Халимагийн их сургууль, Уулын Алтайн Улсын Их сургууль, Барнаулын Техникийн Их сургуультай хамтран «Орос-Монгол үндэсний онцлог, соёл хоорондын харилцаа», «Монгол хэлт ард түмнүүдийн соёлын өвөрмөц байдал», «Монгол-Сибирийн дүрслэх урлагийн гарал үүслийн харьцуулсан судалгаа» төслүүдийг хэрэгжүүлж, хамтарсан ном бүтээлүүдийг гаргасан нь бидний хамтын ажиллагааны чухал үр дүн юм.

Тус сургуулийн Соёл, урлаг судлалын хүрээлэнгийн дэргэд анхны захирал С.Лувсанвандангийн нэрэмжит баримтын санд үе үеийн ахмад судлаачдын хээрийн шинжилгээний болон төслийн тайлангууд, түүхэн ховор гэрэл зураг, кино зохиол, уран сайхны ба баримтат кино зэрэг соёл, урлагийн холбогдол бүхий эх баримтууд хадгалагдаж байгаа бөгөөд энэхүү өвийг Монголын соёлыг судлагч эрдэмтэн судлаачид ашиглах, хамтран бүтээл туурвил нийтлүүлэх бүрэн боломжтой бөгөөд «Соёл, урлагийн архив-лаборатори-музей» байгуулах бидний алс хэтийн зорилгод бүрнээ нийцэхийг Та бүхэнд дуулгахад таатай байна.

Цаашид бид ОХУ-ын эрдэмтэн судлаачид, их, дээд сургуулийн профессоруудтай хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, хээрийн судалгаа хийх, баримт мэдээллийн өв санг хамтран ашиглах зэрэг олон талт ажлыг өргөжүүлэх сонирхолтой байна.

Өнөөдрийн хурлыг зохион байгуулж буй Монголын төр, Монгол улсын ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, Олон улсын Монгол судлалын холбоо, Санкт-Петербург хотын захиргааны Гадаад харилцааны хороонд талархал илэрхийлж байна.